



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/7/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345

Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААР/ЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	8
2.8.2 Авлага	8
2.8.3 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр.....	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	15
2.12. Шилэн дансны мэдээлэл	15
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	15
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
1. Менежментийн захидал	16
3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	16
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БӨМБӨГӨРСУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2020.03.25 № 1/378
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

• 005020330

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар Бөмбөгөр сумын төсөвт байгууллагуудын дүнгээр нийт 204.0 сая, сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 223.6 сая төгрөгийн алдаа илэрч, сумын ЗДТГ "Сөрөг" санал дүгнэлт авсан.

Сумын Засаг дарга Н.Мөнхжаргал бичил уурхай эрхлэгчидтэй "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ" байгуулж, гэрээний 3.1.11, 3.1.12 дахь заалтуудыг зөрчиж 27 иргэн, аж ахуйн нэгжээс 97.0 сая төгрөгийг авснаас 35.0 сая төгрөгийг Хөх толгойн 2 дугаар багийг эрчим хүчинд холбох, 40.0 сая төгрөгийг спорт заалны барилгын ажилд шийдвэргүйгээр олгосон байна.

Дээрх алдаанууд нь "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" гэсэн Үнэн зөв байдал, "Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх" гэсэн Иж бүрэн байх, Аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх" гэсэн Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Бөмбөгөр сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Мөнхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 23-наас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэв.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.-

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Бөмбөгөр сумын Засаг даргын харьяаны төсвийн байгууллагуудад мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн судалгаа гаргуулан авахад сумын Эрүүл мэндийн төвөөс бусад байгууллагуудад бодлогын баримт байхгүй байгаад цаашид анхаарч бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулан батлуулах нь зүйтэй байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Бөмбөгөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд тайлант онд Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс хяналт шалгалт хийгээгүй, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийж, 4 төсвийн байгууллагад 4559.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. Санхүүгийн тайланд хамрагдсан байдал

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	2	-
2	ТБӨӨААН	-	-	-	-	-
	Дүн	2	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бөмбөгөр сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Бөмбөгөр сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь

зохимжтой гэж үзэн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2054144.6 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 20541.4 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2194856.1 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 21948.5 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 1407.1 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг татсантай холбоотой байна.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Хүснэгт 2. Санал дүгнэлтийн хэлбэр

№	Байгууллагын нэр	Аудит хийсэн байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр
1	Засаг даргын Тамгын газар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Сөрөг
2	Эрүүл мэндийн төв		Хязгаарлалттай
3	Ерөнхий боловсролын сургууль	"Глобал капитал" ХХК	Зөрчилгүй
4	Цэцэрлэг		Зөрчилгүй
5	Иргэдийн төлөөлөгчийн хурал		Түүвэрт хамрагдсан
6	Соёлын төв		Түүвэрт хамрагдсан
7	Орон нутгийн хөгжлийн сан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Түүвэрт хамрагдсан
8	Сүм хөгжүүлэх сан		Түүвэрт хамрагдсан

Бөмбөгөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдаж, санал дүгнэлт гаргуулсан 4 байгууллагын 50 хувь нь зөрчилтэй санал дүгнэлт авсан нь дараах шалтгаантай байна. Сумын төрийн сангийн төлөөлөгч сумын ЗДТГ-ийн дансаар бэлэн мөнгө гаргаж, кассын тайлан гаргаагүй, нярав анхан шатны баримтыг өөрийн нэрээр бичиж бүрдүүлсэн байхад хяналт тавиагүй атлаа сумын Соёлын төвийн тэмцээн уралдааны зардлыг бэлнээр гаргахгүй гэсэн тайлбар хийж, Соёлын төв аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан гүйлгээ хийж, шагналын мөнгийг гаргаж авсан байгаа тул төрийн сангийн төлбөр тооцооны журам, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж, төсөвт байгууллагууд адил тэгш шаардлага тавьж хуулиа хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

Хүснэгт 3. Зөрчилтэй дүгнэлт авсан тайлбар

№	Байгууллагын нэр	Зөрчилтэй санал дүгнэлт авсан шалтгаан
1	Засаг даргын Тамгын газар	Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс зарим хөрөнгийг тоолоогүй, худалдан борлуулсны орлого дансанд орсон байхад малыг бүртгэлээс хасаагүй, малын тооны А данс байхгүй, нягтлан бодогч тооллогын бүртгэлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, борлуулсан өвсийг бараа материалаас зарлага гаргаж орлогыг дансанд бүрэн төвлөрүүлээгүй атлаа авлагаар бүртгээгүй, ЗДТГ нь 6007.5 мянган төгрөгийг байгууллагын няравын харилцах дансаар дамжуулан бэлнээр гарган зарцуулж, холбогдох журам, зааврын дагуу кассын тайлан гаргаагүй.
2	Эрүүл мэндийн төв	Байгууллагын 2019 оны төсөвт анх 408497.4 мянган төгрөг баталж, аймгийн Засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 14742.5 мянган төгрөгийг нэмж тодотгон 423239.9 мянган төгрөг болсон байхад төсвөөс Төрийн сан 433239.9 мянган төгрөгийн эрх нээж олгож, батлагдсан төсвийг 10000.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т "Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг БНА-2020/ИСТА-ТТЗ

оролдсон, **санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан**, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу сумын ЗДТГ-ын дарга Б.Чулуундоржид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг сумын Засаг дарга Н.Мөнхжаргалд, Эрүүл мэндийн төвийн төсвийг зөрүүтэй баталсан аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн Т.Гэрэлчулуунд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг дарга С.Батцэцэгт хүргүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг тулган шалгахад байгууллагын нягтлан бодогч өмнөх оны санхүүгийн үзүүлэлтүүдийг Э-тайланд зөрүүтэй оруулсан, тайлант оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар Э-тайланд оруулаагүй, түүнийг санхүүгийн албаны дарга хянаж хүлээн аваагүй зэргээс шалтгаалж, аудитын явцад 50323.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс санхүүгийн байдлын тайланд 2561.7 мянга, үр дүнгийн тайланд 16266.6 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 25194.8 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд 6300.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

Хүснэгт 4. Байгууллагын санхүүгийн тайланд залруулсан алдаа /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Тайлангийн төрөл	Мөнгөн дүн	№	Байгууллагын нэр	Тайлангийн төрөл	Мөнгөн дүн
1	Засаг даргын Тамгын газар	Санхүүгийн байдлын тайлан	1734.4	5	Ерөнхий боловсролын сургууль	Үр дүнгийн тайлан	10933.2
		Үр дүнгийн тайлан	600.0			Мөнгөн гүйлгээний тайлан	24880.3
		Дүн	2334.4			Төсвийн гүйцэтгэлийн тайлан	2800.0
2	Иргэдийн төлөөлөгчийн хурал	Санхүүгийн байдлын тайлан	427.3	Дүн		38613.5	
		Төсвийн гүйцэтгэлийн тайлан	3000.0	6	Цэцэрлэг	Үр дүнгийн тайлан	1283.4
		Дүн	3427.3			Мөнгөн гүйлгээний тайлан	314.5
3	Эрүүл мэндийн төв	Санхүүгийн байдлын тайлан	400.0			6	Цэцэрлэг
		Үр дүнгийн тайлан	3450.0	Дүн	2097.9		
		Дүн	3850.0				

Тус сумын нягтлан бодогч Л.Очирбат, Б.Ганболд нар нь аудитын явцад аудиторын зүгээс тавьсан шаардлагыг хүлээн авдаггүй, ёс бусаар харьцсан асуудлыг анхаарч, цаашид төрийн албан хаагчийн ёс зүйг баримталж, санхүүгийн тайланг тухай бүр нь гаргах, Э-тайланд санхүүгийн үзүүлэлтүүдийг үнэн зөв илэрхийлэн тайлагнаж ажиллахыг анхааруулж байна.

Сумын Засаг даргын харьяаны байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 204.0 сая төгрөгийн 35 алдаа зөрчил илэрснээс 0.4 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 36.9 сая төгрөгийн 12 алдаанд төлбөрийн акт тогтоож, 129.0 сая төгрөгийн 6 алдаан албан шаардлага өгч, 37.7 сая төгрөгийн 15 алдаанд зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 5. Төсвийн шууд захирагчийн тайланд илэрсэн алдаа, зөрчил /сая төг/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Санхүүгийн тайланд залруулах		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХурал	1	0.1	1	3.0					2	3.1
2	ЗДТГ	4	16	3	124.2	3	0	1	0.1	11	140.3
3	Эрүүл мэндийн төв	1	0.6	1	0.0	6	16.7	1	0.3	9	17.6
4	Соёлын төв	1	0.1	1	1.8	1	0.6			3	2.5
5	Сум хөгжүүлэх сан									0	0.0
6	Орон нутгийн хөгжлийн сан	2	0.5							2	0.5
7	Ерөнхий боловсролын сургууль	2	17.3			2	15.2			4	32.5
8	Цэцэрлэг	1	2.3			3	5.2			4	7.5
	Дүн	12	36.9	6	129.0	15	37.7	2	0.4	35	204.0

Эх сурвалж: СТАУС программаас татсан нэгтгэл

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10056.2 мянга, эцсийн үлдэгдэл 24057.0 мянган төгрөг болж, 14000.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эцсийн үлдэгдлийн эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	10,056.2	24,057.0	14,000.8	22.49%
Орон нутгийн хөгжлийн сан	2.9	77,000.3	76,997.4	72.00%
Сум хөгжүүлэх сан	55,303.7	5,890.1	(49,413.6)	5.51%
Дүн	65,362.8	106,947.4	41,584.6	100%

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 24057.0 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас 1293.2 мянган төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудын төвлөрүүлсэн үлдэгдэл, 22763.7 мянган төгрөг нь урьд оны зарцуулаагүй үлдэгдэл байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 77000.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь тухайн онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн 40000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Улаан сайрын 1 дүгээр багийн гүүр барих, 20000.0 мянган төгрөгийн өртөг бүхий сумын төвд гүний худаг гаргах, 9000.0 мянган төгрөгийн өртөг бүхий сумын төвд үерийн далан барих зэрэг ажлууд хийгдээгүйтэй холбоотой байна.

2.8.2 Авлага

Авлага өмнөх оноос 39846.4 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 189836.5 мянган төгрөг болсон байна.

Хүснэгт 7. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,672.7	1,013.2	(659.5)
Байгууллагаас авах авлага	113,500.0	17,000.0	(96,500.0)
Зээлийн хүүгийн авлага	114,510.2	171,823.3	57,313.1
Дүн	229,682.9	189,836.5	(39,846.4)

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оноос 39846.4 мянган төгрөгөөр буурсны гол шалтгаан нь:

1. Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд өмнөх онуудад сумын спорт цогцолборын барилгын 113500.0 мянган төгрөгийг авлагаар тусгасан байсныг 2019 оны санхүүгийн тайлангаар залруулж, авлагаас хасаж, бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн.
2. Сум хөгжүүлэх сангаас тайланд онд 94500.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож авлагаар бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.
Сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль зэрэг байгууллагууд оны эцэст хэмнэгдсэн зардлаас аж ахуйн нэгжид шилжүүлж, авлагаар тусгасан зөрчлийг аудитаар төлбөрийн акт тогтоосон байгаад цаашид дүгнэлт хийж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж, өмнөх онуудын авлага, өглөгийг барагдуулж ажиллах нь зүйтэй байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 178263.0 мянга, эцсийн үлдэгдэл 313668.6 мянган төгрөг болж, 135405.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	109,380.5	126,028.6	16,648.1
Эм боох материал	185.0	877.8	692.8
Бэлэн бүтээгдэхүүн	7,153.6	5,947.0	(1,206.6)
Бичиг хэргийн материал	935.1	776.5	(158.6)
Аж ахуйн материал	43,670.4	49,630.4	5,960.0
Түлш, шатах тослох материал	4,090.8	1,629.9	(2,460.9)
Хүнсний материал	247.6	96.9	(150.7)
Барилгын засварын материал	-	500.0	500.0
Бусад хангамжийн материал	-	115,821.5	115,821.5
Мал амьтад	12,600.0	12,360.0	(240.0)
Дүн	178,263.0	313,668.6	135,405.6

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хандив тусламжаар 11211.5 мянган төгрөгийн бараа материал ирж, төсвийн хөрөнгөөр 375708.4 мянган төгрөгийн бараа материал авч, 22525.8 мянган төгрөгийн бараа материал акталж, 350481.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хүснэгт 9. Байгууллагын бараа материалын судалгаа /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			БҮГД	Хасагдсан		БҮГД	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандив тусламжаар	Шилжүүлэн авсан		Худалдсан, зарцуулсан	Бусад		
1	ИТХурал	1,078.8	14,078.3	-	-	14,078.3	14,196.1	-	14,196.1	961.0
2	ЗДТГазар	24,293.4	60,445.6	-	7,808.0	68,253.6	65,994.2	-	65,994.2	26,552.8
3	Сургууль	74,302.0	99,235.3	5,321.5	-	104,556.8	89,203.6	3,871.6	93,075.2	85,783.5
4	Цэцэрлэг	56,403.2	78,756.1	5,890.0	-	84,646.1	74,120.8	5,474.4	79,595.2	61,454.1
5	Соёл	2,985.0	27,039.4	-	-	27,039.4	16,967.9	1,569.0	18,536.9	11,487.6
6	ЭМТөв	19,200.6	96,153.7	-	185.0	96,338.7	89,999.0	11,610.8	101,609.8	13,929.5
7	ОНХСан	-	-	-	113,500.0	113,500.0	-	-	-	113,500.0
	ДҮН	178,263.0	375,708.4	11,211.5	121,493.0	508,412.9	350,481.5	22,525.8	373,007.3	313,668.5

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4453073.5 мянга, эцсийн үлдэгдэл 4398133.0 мянган төгрөг болж, 54940.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3,155,797.6	3,159,797.6	4,000.0
Тээврийн хэрэгсэл	340,572.6	334,241.2	(6,331.3)
Машин тоног төхөөрөмж	609,793.3	533,493.9	(76,299.4)
Тавилга эд хогшил	224,562.6	237,067.5	12,504.9
Номын фонд	45,039.5	47,741.9	2,702.4
Бусад үндсэн хөрөнгө	2,017.1	4,000.0	1,982.9
Программ хангамж	2,375.0	2,375.0	-
Бусад биет бус хөрөнгө	72,916.0	79,416.0	6,500.0
Дүн	4,453,073.5	4,398,133.0	(54,940.5)

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 72896.0 мянга, бусад эх үүсвэрээр 12150.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй хандиваар 8372.0 мянган төгрөгийн ном нэмэгдсэн ба 148358.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж хасагдсан байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 4858.1 мянга, эцсийн үлдэгдэл 5243.5 мянган төгрөг болж, 385.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	42375.3	36105	-6270.3
Ажилчидтай холбогдсон өглөг	8.4	677.1	668.7
Байгууллагад төлөх өглөг	42366.9	35420.9	-6946
Бусад өглөг	0	7.0	7.0
Урт хугацаат өр төлбөр дүн	0	0	0
Дүн	42375.3	36105.0	-6270.3

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын ЗДТГ, Тариалан эрхлэлтийн дэмжих сантай 2018 оны 05 дугаар сард трактор, дагалдах хэрэгслийн хамт авч, төлбөрийг 2024 он хүртэл 7 жилийн хугацаанд хэсэгчилсэн төлөхөөр гэрээ байгуулсны дагуу санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж, жил бүр 7000.0 мянган төгрөгийн төлж, 2019 оны эцэст 35420.9 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 12. Өглөгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад төлөх
1	Эрүүл мэндийн төв	0.0	19.5	19.5	
2	ОНХС	42,366.9	35,366.9		35,366.9
3	Соёлын төв	0.0	54.9	54.9	
4	ИТХ	0.0	591.6	591.6	
5	ЗДТГ	8.4	72.1	72.1	
	ДҮН	42,366.9	36,105.0	738.1	35,366.9

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцэст ажиллагсдын цалингаас суутгасан тооцсон суутгалыг шилжүүлээгүйгээс төсөвт байгууллагууд өглөгтэй гарсныг цаашид анхаарч, цалингаас суутгасан суутгалыг тухай бүр нь шилжүүлж, Төсвийн тухай хуульд заасны дагуу өглөггүй ажиллах шаардлагатай байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4035556.9 мянга, эцсийн үлдэгдэл 4000195.4 мянган төгрөг болж, 35361.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн, дахин үнэлгээтэй хөрөнгө акталснаас хөрөнгийн дахин үнэлгээ дансанд орсон өөрчлөлт зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 13. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,653,536.96	1,653,536.96	-	0.0
Хуримтлагдсан үр дүн	837,032.52	826,816.10	(10,216.42)	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,544,987.44	1,519,842.35	(25,145.09)	0.0
Дүн	4,035,556.92	4,000,195.41	(35,361.51)	100

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2018 оны төсөв батлах тухай 14/03 дугаар тогтоолд зааснаар Бөмбөгөр сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 2700.0 мянга, аймгийн төсөвт 80600.0 мянга, нийт 83300.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 81057.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 106.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 14. Төвлөрүүлэх орлого / мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	4000	6377.9	2377.9	159.4
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,800.0	3,784.3	1,984.3	210.2
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	800.0	1,710.7	910.7	213.8
1.3.Агаарын бохирдлын төлбөр	1,400.0	882.9	(517.1)	63.1
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	110,750.0	165,283.3	54,533.3	1.5
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	85,000.0	113,155.8	28,155.8	133.1
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	750.0	1,051.5	301.5	140.2
2.3.Газрын төлбөр	13,500.0	38,645.2	25,145.2	286.3
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11,500.0	12,430.8	930.8	108.1
Нийт дүн	14,750.0	171,661.2	56,911.2	160.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 159.4%, аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 160.9 хувиар давуулан биелүүлж, агаарын бохирдлын төлбөрөөс бусад татварын орлого бүрэн биелсэн байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2018.12.19-ний өдрийн 5/5 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 50650.0 мянга, татварын бус орлогыг 5000.0 БНА-2020/СТА-ТТЗ

мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 78357.4 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 140.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 15. Сумын орон нутгийн орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	50,650	68,535	17,885	135.31
1.1.ИОТХ	10,000.0	15,670.4	5,670.4	157
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	26,000.0	34,438.3	8,438.3	132
1.3. Бууны татвар	2,450.0	2,602.0	152.0	106
1.4.Улсын тэмдэгтийн хураамж	2,400.0	4,325.6	1,925.6	180
1.5.Ан амьтны нөөц ашигласны төлбөр	6,500.0	5,553.8	(946.2)	-
1.6.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	3,000.0	5,438.7	2,438.7	181
1.7. Бусад татвар	0.0	206.5	206.5	#DIV/0!
1.8.Нохойны татвар	300.0	300.0	-	100
2.Татварын бус орлого	5,000	9,822	4,822	196.44
2.1.Хүү торгуулийн орлого	5000.0	9822.1	4,822.1	196.4
Нийт дүн	55,650.0	78,357.4	22,707.4	140.80

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс бусад татварын орлого 106-181 хувиар биелсэн байна.

Аймгийн Татварын мэдээтэй татварын орлогын гүйцэтгэлийг тулгахад бусад татварын 206.5 мянган төгрөгөөр зөрсөн бөгөөд энэ нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд Сангийн яамнаас газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг буцаан олгосонтой холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2161039.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2021876.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 139163.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 61.0 хувь буюу 1317316.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 1.5 хувь буюу 32843.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 6.0 хувь буюу 129163.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 25.7 хувь буюу 555617.1 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсвөөс, 2.9 хувь буюу 63100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 600.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 2.9 хувь буюу 63000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 187.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 62500.0 мянган төгрөг оруулахаас 46461.5 мянган төгрөг оруулж, батлагдсан төсвөөс 16038.5 төгрөгөөр тасарсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Иймд цаашид сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөд онцлон анхаарч, зээлийг хугацаандаа төлөөгүй, шүүхийн шийдвэр гарч, эвлэрлийн гэрээ байгуулсан боловч хугацаандаа зээл, хүүг төлөөгүй зээлдэгч нарыг гүйцэтгэх хуудсаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, зээлийг төлүүлж, төсвийг хохиролгүй болгох, санд төвлөрсөн зээлийн эргэн төлөлтийн орлогоос дараагийн иргэнд хөнгөлөлттэй зээлийг олгож, сум орон

нутгийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ажиллахад онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Туслах үйл ажиллагааны орлогоор сумын ЗДТГ 600.0 мянган төгрөг оруулахаар бүрэн оруулж ажиллажээ. Харин сумын Соёлын төвд 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө өгөөгүй ба гүйцэтгэлээр 990.0 мянган төгрөг оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2071018.9 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, төлбөр, хураамжийн зардал 16919.5 мянга, хангамж, бараа материалын зардал 3303.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, ОНХС-ийн зарим ажил хийгдээгүйгээс хөрөнгийн зардалд 71257.4 мянган төгрөгийг зарцуулаагүй зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	314,018.5	313,568.5	450.0	99.9
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	67,035.3	66,415.1	620.2	99.1
Ерөнхий боловсролын сургууль	684,825.3	684,263.9	561.4	99.9
Цэцэрлэг	315,409.8	315,315.6	94.2	100.0
Эрүүл мэндийн төв	433,239.9	433,045.0	194.9	100.0
Соёлын төв	94,847.3	94,629.7	217.6	99.8
Орон нутгийн хөгжлийн сан	139,163.5	67,906.1	71,257.4	48.8
Сум хөгжүүлэх сан	112,500.0	95,875.1	16,624.9	85.2
Нийт дүн	2,161,039.60	2,071,018.99	90,020.61	95.8

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсөв: Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 41901.5.0 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 35188.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдлийн 6708.1 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 4.5 мянган төгрөгийг аймгийн төрийн санд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 17. Нэмэлт төсвийн судалгаа /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	34460.5	27752.4		6708.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2065.0	2065.0	0	0
Соёлын төв	1990.0	1990.0	0	0
Эрүүл мэндийн төв	79.1	79.1	0	0
Цэцэрлэг	3306.9	3302.4	4.5	0
Нийт дүн	41901.5	35188.9	4.5	6708.1

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.10.1 Балансын данстай холбоотой асуудал

Бөмбөгөр сумын Спорт цогцолборын барилгын санхүүжилтэд 2019 онд “Вояжир менерал ресурс” ХХК-аас 30,000,000, “Эл Ти Ди” ХХК-аас 10,000,000, нийт 40,000,000 төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгж “Халзан хайрхан” ХХК-ийн дансанд шилжүүлсэн байхад

санхүүгийн тайланд тус цогцолбортой холбоотой эргэлтийн хөрөнгийг тус дүнгээр нэмэгдүүлж бүртгээгүй байна.

Өмнөх онуудад тус цогцолбортой холбоотой хандивын талаар “Халзан хайрхан” ХХК-аас тодруулахад 2018 онд иргэн Рэгсүрэнгээс 40,000,000 төгрөг, “Өндөр толгой” ЗБН-өөс 10,000,000 төгрөг, “Тогоотын өгөөж” ЗБН-өөс 20,000,000 төгрөг буюу нийт 70,000,000 төгрөг авсан байхад тус цогцолборын эргэлтийн хөрөнгийн дүнг дээрх дүнгээр нэмэгдүүлж бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Иж бүрэн байх, Оршин байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.10.2. Балансын данстай холбоотой асуудал

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хөх толгойн 2-р багийг эрчим хүчинд холбох ажилд 10,000,000 төгрөг баталж, “Их хонгор энерги” ХХК-тай 2019.06.13-ны өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, 2019.06.28-ны өдөр гүйцэтгэгч “Их хонгор энерги” ХХК-10000000 төгрөгийг шилжүүлсэн байна.

Сумын Засаг дарга Н.Мөнхжаргал, бичил уурхай эрхлэгчидтэй “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ” байгуулж, гэрээний 3.1.11-т “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд барьцаа хэлбэрээр төвлөрүүлэх”, 3.1.12-т “Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд буцаан зарцуулах” гэж заасныг зөрчин, гэрээг байгуулсан 11 бичил уурхай эрхлэгчдээс нийт 35,000,000 төгрөгийг “Их хонгор энерги” ХХК-ийн Голомт банкны 1415122101 тоот дансанд шилжүүлж, нийт 45,000,000 төгрөгөөр Хөх толгойн 2-р багийг эрчим хүчинд холбох ажлыг гүйцэтгэсэн байна.

Барилга байгууламжийн ашиглалтад оруулах техникийн комиссын даргаар сумын Засаг дарга Н.Мөнхжаргал, нарийн бичгийн даргаар ЗДТГ-ын дарга Б.Чулуундорж, Засаг даргын орлогч Ч.Батхуяг, сумын эрчим хүчний ахлах техникч Б.Цэвэгдорж нар хүлээн авсан тухай комиссын акт үйлдсэн боловч /хүлээн авсан он, сар, өдрийг бичээгүй/ холбогдох газраар шийдвэр гаргуулж, хөрөнгийг орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал, Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.10.3. Балансын данстай холбоотой асуудал

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Соёлын төвд 2,500,000 төгрөгийн хяналтын камер худалдан авч, байршуулан ашиглаж байхад хөрөнгийг орлогод бүртгээгүй байна.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал, Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Бөмбөгөр сумын Спорт цогцолборын барилгын олгосон санхүүжилтэд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг тодруулж шалгах, бичил уурхай эрхлэгчдээс авч байгаа барьцааны төлбөрийг хуульд нийцэж байгааг тодруулан шалгах шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байгаа нь хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой, Санхүүгийн хяналт, аудитын албанаас

№	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
